



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



ХАДАНД МӨНХӨЛСӨН УРЛАГ

Түүх, Ойллого, Ярилцаан

Монгол Улсын Ерөнхийлөгч, ЮНЕСКО-ийн ивээл дор зохион
байгуулж буй Олон улсын эрдэм шинжилгээний хурал

ХӨТӨЛБӨР

2016 оны 5 дугаар сарын 30-31. Монгол Улс, Улаанбаатар хот



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ





МЭНДЧИЛГЭЭ



Зураг. Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутагт орших буган хөшөөдийн дэргэд

Эртний нүүдэлчдийн оюун санааны хувьсал, тухайн цагийн нийгэм, соёл, аж ахуйн бодит байдлыг тусгасан дурсгал бол хадны зураг билээ. Монгол орон хадны сийлмэл зургийн дурсгалаар баялаг орны нэг төдийгүй тэдгээрийн агуулга, зохиомж, түүх соёлын үнэ цэнэ зэргээрээ дэлхий дахины анхаарлыг зүй ёсоор татдаг юм.

ЮНЕСКО-ийн Дэлхийн соёлын өвд Монголын гурван газар багтсаны нэг нь Монгол Алтайн нурууны Хадны зургийн цогцолбор дурсгал билээ. Иймээс Монгол Улс Алтайн нурууны болон бусад газрын хадны зургийн хадгалалт хамгаалалтад онцгой анхаарал хандуулах төдийгүй хадны зургийн судалгааг улам гүнзгийрүүлэх үүргийг хүн төрөлхтний өмнө хүлээсэн юм.

Ерөнхийлөгчийн Тамгын газар, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнтэй хамтран Монгол Улсын төдийгүй хүн төрөлхтний соёлын өв-хадны зургийн дурсгалыг хадгалж хамгаалах, судалгааны ажлыг улам гүнзгийрүүлэх, залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх, сурталчлан таниулах ач холбогдолтой “Хадны зураг” төслийг эхлүүлэн ажиллаж байна.

Уг төслийн хүрээнд “Хаданд мөнхөлсөн урлаг: Түүх, ойлого, ярилцаан” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Монгол Улсын Ерөнхийлөгч, ЮНЕСКО-ийн ивээл дор зохион байгуулж байна. Хуралд гадаадын 15, дотоодын 10 эрдэмтэд, 60 гаруй судлаач, сонирхогчид оролцож, дэлхийн өв болсон хадны зургийг судлах арга зүй, түүнийг тайлан тайлбарлах, хадгалж хамгаалах талаар бусад улс орнуудад явуулж байгаа туршилагаас хуваалцах бөгөөд Монгол орны нутаг дэвсгэрт байгаа хадны зургийг судлах, тайлах чиглэлээр явуулж байгаа эрдэм шинжилгээний ажлын үр дүнг хэлэлцэх юм. Энэхүү эрдэм шинжилгээний бага хурал нь Монголын хадны зургийг судлах ажилд дорвитой хувь нэмэр болж, улмаар олон улсын хүрээг хамарсан, ЮНЕСКО-гийн төсөл болгох зорилгын эхний алхам юм. Манай орны санаачилж буй энэ төслийг олон улсын байгууллагууд, тухайлбал, ЮНЕСКО, Олон улсын Философи, Хүмүүнлэгийн ухааны холбоо зэрэг байгууллагууд онцгой анхаарч байна.

Бага хурлыг зохион байгуулахад санхүүгийн болон техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлсэн “Соёлын харилцаа-нэгдмэл ертөнц” олон улсын сан, ШУТИС, Чулуун Шастир, Мэргэн нум зэрэг төрийн бус байгууллага, Монголын Үндэсний музей, Монголын үндэсний олон нийтийн телевиз, Малчин телевиз, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр, Соёл Урлагийн их сургууль болон санаачилгыг дэмжигч олон түмэнд гүн талархал илэрхийлье.

“Хаданд мөнхөлсөн урлаг: Түүх, ойлого, ярилцаан” сэдэвт бага хурал олон орны эрдэмтдийн цаашдын хамтын ажиллагааг өргөтгөх, дэлхийн соёлын өв болсон хадны зургийн талаарх судалгааг улам гүнзгийрүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Төслийн удирдагч,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга

Балар болон Өнө эртний судлалын Олон улсын нийгэмлэгийн гишүүн



Пунцагийн Цагаан



Хурлын дарга
Пунцагийн ЦАГААН

Олон улсын эрдмийн зөвлөл
Дэндэвийн Бадарч (ЮНЕСКО)
Али Мусса Айти (ЮНЕСКО)
Августин Холл (Франц)
Пунцагийн Цагаан (Монгол)

Зохион байгуулах хороо

П.Цагаан
Д.Цахилгаан
Г.Батсүх
Б.Очирбат
С.Чулуун
Д.Цэвээндорж
Б.Сүхбаатар
Н.Батболд
Б.Баяр
Б.Булганбаяр
Б.Мөнххүж

Зохион байгуулагчид

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
“Соёлын харилцаа – Нэгдмэл ертөнц” олон улсын сан
Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн
Монголын Үндэсний музей
Мэргэн нум ТББ
Чулуун шастир ТББ

Хурлын байр

Соёмбо танхим
Бест Вестерн Премьер Туушин зочид буудал,
Монгол Улс, Улаанбаатар 14200, Ерөнхий сайд Амарын гудамж 15.

**Монгол Улсын Ерөнхийлөгч, ЮНЕСКО-ийн ивээл дор
зохион байгуулж буй Олон улсын хурал, Экспертүүдийн уулзалт**

Даваа гариг, 2016 оны 5 дугаар сарын 30

НЭЭЛТИЙН ХУРАЛДААН

(9:00-10:00)

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн ЭЛБЭГДОРЖ

Дэндэвийн БАДАРЧ, ЮНЕСКО-гийн Нийгмийн болон Хүмүүнлэгийн шинжлэх ухааны секторын Нийгмийн өөрчлөлт, соёл хоорондын харилцааны хэлтсийн захирал

Хадны зургаас сэдэвлэн бүтээсэн Ш.Тэнгисболдын уран бүтээлийн хэсгээс

Уран зургийн үзэсгэлэн

ХУРАЛДААН

Эхний хуралдаан. ХАДНЫ ЗУРАГ СУДЛАХ АРГА ЗҮЙ, УХАГДАХУУН

(10:00 - 13:00)

Хурал хөтлөгч: П.Цагаан, Төслийн ахлагч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Балар эртний болон Өнө эртний шинжлэх ухааны Олон улсын нийгэмлэгийн гишүүн (UISSP)

Үндсэн илтгэгч: Доктор Августин Ф.С. Холл, Парисийн Вест Нантерре Ла Дефенсегийн их сургуулийн Хүн судлалын тэнхимийн профессор, Франц

Хадны зураг ба Археологи: Уялдаа холбоо, сэдэв болон он цагийн хэлхээсийг нээн илрүүлэх нь

Доктор Вильям В. Фицхью, Вашингтон дахь Смитсоны хүрээлэнгийн Хойд туйл судлалын төвийн захирал, АНУ

Хадны зураг судлалд шинжлэх ухааны үүднээс хандах нь

Доктор Роберт Г. Беднарик, Хадны зургийн талаарх судалгааны байгууллагуудын олон улсын холбоо (IFRAO)-ны гүйцэтгэх захирал, Австрали

Филомететикс: Хадны зураг судлахад шинэ арга хэрэглэх нь

Доктор Жан-Луис Ле Квелек, Африк судлалын хүрээлэн(IMAf)-гийн эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, Франц

Завсарлага (11:00 -11:30)

Дэлхийн хамгийн эртний хадны зураг

Доктор Иполито Колладо Гиралдо, Экстремадур тойргийн Засгийн газрын соёлын яамны Археологийн газрын дарга, Испани

Монголын Алтай нурууны хадны зураг: Чулуун дээр үлдсэн эрт галавын байгаль орчны ул мөр

Доктор Эстер Якобсон – Тефер, Орегоны их сургуулийн Урлаг, уран барилгын тэнхимийн хүндэт профессор, АНУ



**ЮНЕСКО–гийн Соёлын өвийн урдчилсан жагсаалтад орсон
хадны зураг бүхий газрууд**

*Доктор Екатерина Девлет, Оросын ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Эрдэмтэн
нарийн бичгийн дарга, Эрт галавын урлаг судлалын төвийн эрхлэгч, ОХУ*

Хэлэлцүүлэг (12:30-13:00)

Үдийн цай (13:00 – 15:00)

**Хоёрдугаар хуралдаан. МОНГОЛЫН НУТАГ ДАХЬ ХАДНЫ ЗУРГУУД
(15:00-17:30)**

*Хурал хөтлөгч: Доктор, профессор Д.Цахилгаан, Чулуун шастир ТББ-ын Дэд
Ерөнхийлөгч, Монгол Улсын Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд*

*Үндсэн илтгэгч: Доктор Вильям В. Фицхью, Вашингтон дахь Смитсоны
хүрээлэнгийн Хойд туйл судлалын төвийн захирал, АНУ*

Говь-Алтайн нуруун дахь хадны зургийн цогцолбор
Доктор Н.Батболд, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Монгол Улс

**Билүүтийн хадны зургийн цогцолбор: Монголын Алтайн нуруун дахь Эрт
галавын шүтээн газар**

*Доктор Ричард Кортум, Дорнод Теннесси мужийн их сургуулийн Философи,
Хүмүүнлэгийн тэнхимийн хүндэт профессор, АНУ*

Монгол Алтайн нурууны хадны зурганд мөнхөрсөн эвэрт амьтад
*Доктор Д.Цэвээндорж, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн профессор,
Монгол Улс*

Завсарлага (16:00 -16:15)

Монгол Алтайн Хэмцэгийн хадны зураг

*Доктор Б.Өмирбек, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Баян–Өлгий аймаг дахь
Нийгэм эдийн засгийн бодлогын судалгааны төвийн судлаач, Монгол Улс*

Эрт галавын үе хэрхэн түүхийн нэг хэсэг болох вэ?:

Монголын түүх судлалд эрт үеийг тусгасан байдал

Доктор Хироки Ока, Тохоку их сургуулийн Зүүн Хойд Ази судлалын төвийн захирал, Япон

Маген Дэвид үнэхээр Монголоос олдсон

Доктор Хатагин Го.Аким, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Монгол Улс

Хэлэлцүүлэг (17:15-17:40)

18:30

*Урлагийн тоглолт болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын
газраас зохион байгуулах хүлээн авалт
(Урилгаар)*

Мягмар гариг, 2016 оны 5 дугаар сарын 31

Гуравдугаар хуралдаан. ХАДНЫ ЗУРГИЙГ ТАЙЛАХ НЬ

(9:00 - 12:00)

Хурлын хөтлөгч: Г.Батсүх, Чулуун шастир ТББ-ын Дэд ерөнхийлөгч, Монгол Улсын онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд

Үндсэн илтгэгч: Доктор Роберт Г. Беднарик, Хадны зургийн талаарх судалгааны байгууллагуудын олон улсын холбоо(IFRAO)–ны гүйцэтгэх захирал, Австрали

‘Сүйт бүсгүйчүүл’: Уэн Дербуаны хадны зургийг унших нь

Доктор Августин Ф.С. Холл, Парисийн Вест Нантерре Ла Дефенсе их сургуулийн Хүн судлалын тэнхимийн профессор, Франц

Хуучны үлгэр домгийг шинээр зураглан үзүүлэх нь: Төв Чилийн Валпаразо хотын эртний дүүрэг дэх графитийн цогцолбор

Доктор Жеорже Нашь, Бристолийн их сургуулийн Археологи болон Хүн судлалын тэнхимийн профессор, СЛР Зөвлөх үйлчилгээний компанийн ажилтан, Англи

Хадны зураг дахь хүний нүүр царайг ажиглах нь

Доктор С.Бадрал, Урлаг судлалын дэд профессор, зураач, барималч, Монгол Улс

Өвөр Монгол дахь Еншаан уулын хадны зураг дахь нүүрний багуудын дүрсний уг гарлыг судлах нь

Доктор Яаша Жан, Хятадын хадны зургийн урлагийг судлах холбооны захирал (RARAC), БНХАУ

Завсарлага (10:20 -10:40)

Рашаан хадан дээрх “Тамгат бүжигчин” зургийн нууцыг тайлан унших нь

Доктор С.Дулам, Соёл Урлагийн их сургуулийн профессор, Монгол Улс

Голоцены үеийн Улсан хотын Таэва мөрний дунд болон адаг хавийн хүмүүний амьдрал, байгаль орчны өөрчлөлтийг – Бангудэн чулуун дээр сийлсэн зургийг үндэслэн судалсан нь

Доктор Ёон, Сун -Ок, Күнххи Их сургуулийн профессор, БНСУ

Доктор Хван, Санг- иль, Кунгпук үндэсний их сургуулийн профессор, БНСУ

Гобустаны Хүрэл зэвсгийн үеийн хадны зураг ба тэдгээрийг тайлбарласан зарим арга

Рахман Абдуллаев, ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн бүртгэлд орсон Гобустаны түүх уран сайхны үндэсний музейн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Азербайжан



Монголын зарим хийсвэр хадны зургийг тайлбарлах нь
*Доктор Ю.Болдбаатар, Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн их сургуулийн
дэд профессор, Монгол Улс*

Хэлэлцүүлэг (12:00-12:20)

ХААЛТЫН ХУРАЛ

(12:20-13:00)

Үндсэн илтгэгчдийн товч тайлан

Профессор Августин Ф.С. Холл
Доктор Вильям В. Фицхью
Доктор Роберт Г. Беднарик

Хурлаас гарах бичиг баримтыг батлах

Доктор Н.Батболд

Хаалтын үг хэлэх

Лувсаннямын ГАНТӨМӨР
Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

Хурлын дарга үг хэлэх

Пунцагийн ЦАГААН